



2018 оны 06 дугаар сарын 28
№24/1029/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**“Монгол Улсын эдийн засаг,
нийгмийг 2019 онд хөгжүүлэх
үндсэн чиглэл батлах тухай”**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Улсын Их Хурлын гишүүнээс
чөлөөлөх тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт**

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

226.	“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай”	Дугаар 37	742
227.	Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 48	786
228.	Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 49	786
229.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 50	787
230.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 51	787

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

231.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 08	788
------	---	-----------	-----



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль, бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2018 оны
37 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

№	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2019 онд хүрэх түвшин, үр дүн	2019 онд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
Зорилт 1. Эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг дээшлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
1.1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /цаашид "МУТХҮБ-2030" гэх/-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр/ цаашид "ЗГҮАХ" гэх/-ийн 1.1, 1.2 дахь заалт	Татварын орчныг шинэчлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ний бодит өсөлт, хувиар	8.0	-	Засгийн газар, Сангийн яам /цаашид "СЯ" гэх/
1.2	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.4 дэх заалт	Зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх	Ажиллах хүчийн оролцооны түвшин, хувиар Ажилгүйдлийн түвшин, хувиар	64.0 7.5	- -	Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /цаашид "ХНХЯ" гэх/



Зорилт 2. Макро эдийн засгийн эрсдэл даах чадавхийг дээшлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангана.						
2.1	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 1.4 дэх заалт	Төсвийн зарцуулалтыг оновчтой болгох, зардлын менежментийг шинэтгэх замаар төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн бодлогын орон зай бий болгох	Нэгдсэн төсвийн алдагдлын дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар	6.1	-	СЯ
		Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар	Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар	55.3	-	
2.2	МУТХҮБ-2030-ын 2.1 дэх заалт	Валютын орох урсгал өндөр уед гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх	Гадаад валютын нөөц, импортын сарын хэрэгцээгээр	10.0-аас доошгүй	-	Монголбанк, СЯ
2.3	МУТХҮБ-2030-ын 2.1, ЗГҮАХ-ийн 1.6 дахь заалт	Төсөв, мөнгөний бодлогыг оновчтой хослуулах замаар инфляцийг зорилтот түвшинд байлгах	Инфляцийн түвшин, оны эцэст хувиар	8.0-аас ихгүй	-	Монголбанк, Засгийн газар
2.4	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.6 дахь заалт	Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин, дэд бүтцийг боловсронгуй болгож, бизнес эрхлэгчдэд хямд өртөгтэй санхүүжилт татах боломжийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гэх/, Монголбанк, СЯ
2.5	МУТХҮБ-2030-ын 2.1 дэх хэсэг	Банк, санхүүгийн тогтолцооны эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Монголбанк, СЗХ, СЯ
2.6	"Гурван тулгуурт хөгжлийн бодлого" /цаашид "ГТХБ" гэх/-ын 2.1.3 дахь заалт	Хөгжлийн бодлого төлөвлөлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Үндэсний хөгжлийн газар /цаашид "УХГ" гэх/

2.7	МУТХҮБ-2030-ын 2.1 дэх хэсэг	Зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Монголбанк, СЯ, СЗХ
ХОЁР-ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО						
Зорилт 3.Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.						
3.1	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /цаашид "ТХХААТББ" гэх/-ын 4.1.13 дахь заалт, ЗГҮАХ-ийн 1.23, 2.20, 2.23, 2.48 дахь заалт,	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо /Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хууль, Хоршооны тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль/	3	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид "ХХААХҮЯ" гэх/
3.2	ЗГҮАХ-ийн 2.25 дахь заалт	Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх, мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, түүний техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх	Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх сум, дүүргийн тоо Мэдээллийн онлайн системийг бүрдүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх сум, дүүргийн тоо	339 339	37.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ, Үндэсний статисти-кийн хороо /цаашид "ҮСХ" гэх/



3.3	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/ Вакинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга	61	30.7 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ
				200		
3.4	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.38 дахь заалт	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах	Цэвэр Үүлдрийн үхрийн тооны өсөлт, мянган толгой Гахай, тахианы аж ахуйн тооны өсөлт, хувиар Зарим бүтээг- дэхүүний импортыг бууруулах хувь: -Тахианы өндөг -Эгтийн бал -Хүчит тэжээл	5	20.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшил	ХХААХҮЯ
				4		
				13.0		
				18.0		
Зорилт 4.Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулна.						
4.1	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34 дэх заалт	"Мах, сүүний андугаар аян"-ы хүрээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн аргаар боловсруулах махны хэмжээ, мянган тонн Үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээ, сая литр	24.6	25.3 Улсын төсөв	ХХААХҮЯ
				85.0		

4.2	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ТХХААТББ-ын 3.1.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.39, 2.40, 2.45 дахь заалт	Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангалтыг нэмэгдүүлэх	Өвөл, зуны хүлэмжийн нэмэгдэх талбай, га	10.0	5.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ, Хөгжлийн банк, Аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "АНЗДТГ" гэх/
			Өвөл, зуны хүлэмжээс хураан авах ургац, тонн	3500	10.0 Хөгжлийн банк	
4.3	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах	Нэмэгдэх зоорийн багтаамж, тонн	2000	2.6 Улсын төсөв	ХХААХҮЯ, СЯ
			Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх хувь	5.0	5.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	
4.3	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах	Жимс, жимсгэнэ тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ, га	10	5.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ, СЯ
			Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин, хувиар	50.0	2.0 Улсын төсөв, 7.0 Гадаад эх үүсвэр	
			Барилгын ажлын явц, хувиар	80.0	59.0 Хөгжлийн банк	



4.4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт	Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн тариалалтыг дэмжих	Хураан авах үр тарианы хэмжээ, мянган тонн	400	-	ХХААХҮЯ, СЯ
				1000	18.0 Хувийн хөрөнгө оруулалт	
4.5	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /цаашид "ТАУТББ" гэх/-ын 4.2.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.48, 2.50, 2.55, 2.56, 2.57 дахь заалт	"Үйлдвэржилт 21.100" үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	30.0	251.0 Гадаад эх үүсвэр, Хувийн хөрөнгө оруулалт	ХХААХҮЯ, СЯ
				80.0	13.2 Гадаад эх үүсвэр	
4.6	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.48, 2.51 дэх заалт	"Ноолуур" хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20.0	22.6 Улсын төсөв	ХХААХҮЯ
4.7	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.50, 2.15, 2.54 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэрийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	Санхүүжүүлэх төслийн тоо	400-аас доошгүй	200.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ

4.8	МУТХУБ-2030-ын 2.1.3, ЗГҮАХ-ийн 2.57 дахь заалт	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах	Ажлын явц, хувмар	30.0	130.0 Гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ, Барилга, хот байгуулалтын яам /цаашид "БХБЯ" гэх/, Эрчим хүчний яам /цаашид "ЭХЯ" гэх/, АНЗДТГ
4.9	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58 дахь заалт	Төрөөс дотоодын худалдан авалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх	Дотоодын худалдан авалтын өсөлтийн хувь	10.0	-	ХХААХҮЯ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар /цаашид "ТӨБЭЗ" гэх/
4.10	МУТХУБ-2030-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23 дахь заалт	Орон нутгийн мэргэжлийн хяналтын лабораторийн ажиллах нөхцөлийг сайжруулах	Ашиглалтад орох лабораторийн барилга Шинээр ашиглалтад орох явуулын лаборатори	1 12	1.5 Улсын төсөв	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /цаашид "МХЕГ" гэх/



Зорилт 5.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.					
5.1	МУТХУБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид "ТЭБСББ" гэх-ын 3.2.2 дахь заалт, ЗГУАХ-ийн 2.59-2.61 дэх заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх	1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	43.5	Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам /цаашид "УУХУЯ" гэх/, Улсын төсөв
			Улсын геологийн иж бүрдэл зургийг "К" хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлын явц, хувиар	50.0	
			Агаарын геофизикийн судалгааны ажлын хүрээнд Ховд-1 төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20.0	
			Монгол орны геохимийн 1:100000-ын масштабын зураг зохиох ажлын явц, хувиар	20.0	
			Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын тоо	3	

5.2	<p>Нутаг дэвсгэрийн ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах, геоэкологи, гидрогеологийн судалгаа хийх, геомэдээллийн санг баяжуулах сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэх</p> <p>МУТХУБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, ТЭБСББ-ын 3.2.2 дахь заалт ЗГҮАХ-ийн 2.59-2.61 дэх заалт</p>	Голлох ашигт малтмалын хэтийн төлвийн судалгааны ажлын тоо	1	6.2 Улсын төсөв	УУХҮЯ
		Алт-2 хөтөлбөрийн хүрээнд Монгол орны алтны хэтийн төлвийг тогтоох эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	60.0		
		Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах судалгааны ажлын тоо	1		
		Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын хүрээнд хэрэгжүүлэх төслийн тоо	1		
		Үндэсний геологийн албыг байгуулах ажлын явц, хувиар	100		



5.3	МУТХУБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Оюутолгойн далад уурхайн бүтээн байгуулалтын явц, хувиар Тавантолгойн орд ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын явц, хувиар	60.0	2,400.0 Хувийн хөрөнгө оруулалт	УУХҮЯ
				20.0	380.0 Хувийн хөрөнгө оруулалт	
5.4	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73 дахь заалт	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн ажлын явц, хувиар	50.0	250.0 Хөгжлийн банк	УУХҮЯ, ҮХГ
			Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	10.0	607.5 Хувийн хөрөнгө оруулалт	
			Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	10.0	- Хувийн хөрөнгө оруулалт	
			Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон Төмөртэйн ордын баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлын явц, хувиар	10.0	75.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл /цаашид "ТХХТ" гэх/	

5.5	<p>МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.17 дахь заалт</p>	<p>Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлэх</p>	<p>Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны нэмэгдэх хувь</p>	10.0	-	УУХҮЯ
Зорилт 6. Эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.						
6.1	<p>МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /цаашид "ТЭХТБ" гэх/-ын 3.2.1.2, 4.1.1.4, ЗГҮАХ-ийн 2.97 дахь заалт</p>	<p>Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх</p>	<p>Эрдэнэтийн ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар</p> <p>Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийн гэрээ, хэлэлцээрийн ажлын явц, хувиар</p> <p>Гуравдугаар ДЦС-ыг 250 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар</p>	50.0	52.4 Гадаад эх үүсвэр	ЭХЯ



6.2	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 4.1.1.1, 3.2.1 ЗГҮАХ-ийн 2.98 дахь заалт	Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих	Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц барих төслийн санхүүгийн хаалт хийх ажлын явц, хувиар	100	23.9 Хувийн хөрөнгө оруулалт	ЭХЯ, УУХҮЯ, ҮХГ
			Багануурын 700 МВт-ын ДЦС барих төслийн барилгын ажлын явц, хувиар	20.0	239.4 Хувийн хөрөнгө оруулалт	
			Баруун бүсийн 60 МВт-ын ДЦС-ын барилгын ажлын явц, хувиар	20.0	47.9 Хувийн хөрөнгө оруулалт	
			Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх ажлыг эхлүүлэх төслийн гэрээ, хэлэлцээрийн ажлын явц, хувиар	100	-	
			Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-г боловсруулж, хүчин чадлыг өргөтгөх төслийн, гэрээ, хэлэлцээрийн ажлын явц, хувиар	100	0.075 Гадаад эх үүсвэр	

6.3	<p>МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 4.1.1.2, ЗГУАХ-ийн 2.103 дахь заалт</p>	<p>Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх</p>	<p>Төслийн гэрээ хэлэлцээрийн ажлын явц, хувиар</p>	100	-	<p>ЭХЯ, СЯ, УУХУЯ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /цаашид “БОАЖЯ” гэх/</p>
6.4	<p>МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 2, ТЭХТББ-ын 3.2.6, ЗГУАХ-ийн 2.104 дахь заалт</p>	<p>Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх</p>	<p>Эрдэнэбүрэнгийн 64 МВт-ын УЦС-ын суурь судалгааны ажлын явц, хувиар</p>	100	<p>7.2 Гадаад эх үүсвэр</p>	<p>ЭХЯ, БОАЖЯ,</p>
6.5	<p>МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.6, 3.2.5.3, 4.1.1.5, ЗГУАХ-ийн 2.105 дахь заалт</p>	<p>Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг эхлүүлэх</p>	<p>Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн барилгын ажлын явц, хувиар</p>	30.0	<p>34.2 Гадаад эх үүсвэр</p>	<p>Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт 260 км ЦДАШ, 220 кВ-ын дэд станц барих, Оюутолгой, Тавантолгой дэд станцуудыг өргөтгөх барилгын ажлын явц, хувиар</p>
6.5				50.0	<p>111.1 Гадаад эх үүсвэр</p>	

6.6	МҮТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.4, ЗГҮАХ-ийн 2.106 дахь заалт	Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Аймгийн төвүүдийн дулааны станцын барилгын ажлын явц, хувиар Төвлөрсөн Дулаан хангамжийн систем-тэй хот суурин газрын дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх барилгын ажлын явц, хувиар	20.0	119.7 Гадаад эх үүсвэр	ЭХЯ, СЯ
				70.0	25.7 Улсын төсөв	
6.7	ТЭХТББ-ын 3.2.5, ЗГҮАХ-ийн 2.108 дахь заалт	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, цахилгаан түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, алдагдлыг бууруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Багануур зүүн өмнөд бус, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг 4 аймагт хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	50.0	23.9 Гадаад эх үүсвэр	ЭХЯ, СЯ
6.8	ЗГҮАХ-ийн 2.110 дахь заалт	Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлэх	Метан хийн нөөцийг бүрдүүлэх, салбарын хөгжлийг дэмжсэн бүтэц зохион байгуулалт бий болгох, норм, дүрэм стандартуудыг батлуулах ажлын явц, хувиар Хийн хангамжийг хөгжүүлэх дэд бүтцийг байгуулах зураг төслийн ажлын явц, хувиар	100	0.06 Улсын Төсөв	ЭХЯ
				20.0	5.0 Улсын төсөв	ЭХЯ, БОАЖЯ



6.9	ТЭХТББ-ын 4.1 дэх заалт	Эрчим хүчний нормативын баримт бичгийн тогтолцоог төгөлдөржүүлж, олон улсын стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг сайжруулах	Боловруулах дүрэм, норм, нормативын баримт бичгийн тоо	2 дүрэм, 2 норм, 5 стандарт	0.3 Улсын төсөв	ЭХЯ
Зорилт 7. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.						
7.1	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГУАХ-ийн 2.107 дахь заалт	Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөх	Ашиглалтад оруулах хатуу хучилттай авто замын урт, км Ашиглалтад оруулах төмөр бетон гүүрийн урт, метр	500 130	77.2 Улсын төсөв, гадаад эх үүсвэр, ТХХТ 4.9 Улсын төсөв	Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид "ЗТХЯ" гэх/, ҮХГ
7.2	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГУАХ-ийн 2.121 дэх заалт	Авто замын засвар, арчлалтын хугацааг уртасгах, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	Бус нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн хэрэгжилтийн явц, хувиар Улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын ажлын явц, хувиар	10.0 100	15.0 Гадаад эх үүсвэр 15.2 Улсын төсөв	ЗТХЯ, АНЗДТГ
		Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах, түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээ авах	Яармагийн 260 ум шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах барилгын ажлын явц, хувиар	100		

7.3	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.119 дэх заалт	Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих ажлын явц, хувиар	100	64.4 Гадаад эх үүсвэр	ЗТХЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид “НЗДТГ” гэх
			Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих ажлын явц, хувиар		
7.4	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.113 дахь заалт	Тэвэрийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	30.0	36.0 Гадаад эх үүсвэр	
			Тусгай замын автобус (BRT) системийг нэвтрүүлэх 1 дүгээр шатны барилгын ажлын явц, хувиар		
7.4	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.113 дахь заалт	Барилгын ажлын явц, хувиар	100	7.7 Гадаад эх үүсвэр	ЗТХЯ, АНЗДТГ

7.5	МУТХУБ-2030-ын 2.1.15, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.108, 2.112 дэхь заалт	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	Төмөр замын зүүн, хойд коридорыг бий болгох төвийн коридорыг шинэчлэх барилгын ажлын явц, хувиар	30.0	780.0 ТХХТ, Гадаад эх үүсвэр	ЗТХЯ, Улаанбаатар төмөр зам
7.6	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114 дэх заалт	Орон нутгийн нисэх буудлуудын чадавхыг дээшлүүлэх	Их засвар хийгдэх төмөр замын урт, км Ховд, Өмнөговь аймгийн нисэх буудлуудыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлын явц, хувиар	50 40.0	37.2 Гадаад эх үүсвэр 78.5 Гадаад эх үүсвэр	ЗТХЯ, Иргэний нисэхийн ерөнхий газар
ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО						
Зорилт 8.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангана.						
8.1	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.79 дэх заалт	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах	Төсөл боловсруулах ажлын явц, хувиар	70.0	2.5 Улсын төсөв	БХБЯ, УХГ, СЯ, Бусад холбогдох яамд, АНЗДТГ
			Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах хувь	10.0	2.5 Улсын төсөв	

8.2	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.81 дэх заалт	Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох	Шинээр байгуулах GNSS (GPS)- ийн байнгын ажиллагаатай суурин станцын тоо	15	0.6 Улсын төсөв	БХБЯ
			Газар зүйн 350 мянган нэрийн тодруулга, солбицолжуулалт хийх, хувиар	30.0	1.3 Улсын төсөв	
8.3	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.85 дахь заалт	Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх	Өндрийн II дугаар ангийн сүлжээний давтан хэмжилт, хайгуул судалгаа, хэмжилт хийх цэгийн тоо	681	1.6 Улсын төсөв	БХБЯ, ЗТХЯ, АНЭДТГ
			Боловруулах ерөнхий төлөвлөгөөний тоо	10	4.4 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	



8.4	МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.91 дэх заалт	Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих болон өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, хувиар	30.0	172.2 Гадаад эх үүсвэр	БХБЯ, АНЗДТГ
				100		
8.5	МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2	"Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих барилгын ажлын явц, хувиар	30.0	19.0 Гадаад эх үүсвэр	БХБЯ, АНЗДТГ
				100		
8.6	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, 2.3.1. Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.96 дахь заалт	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх	Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сулжээг барьж байгуулах ажлын явц, хувиар	80.0	39.8 Гадаад эх үүсвэр	БХБЯ, НЗДТГ
				3	15.0 Гадаад эх үүсвэр	

8.7	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.76, 3.4.3 дахь заалт	Гэр хороололд амины орон сууц барихад зориулж урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох	Ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо	6000	130.0 Улсын төсөв, 249.3 Бусад эх үүсвэр	БХБЯ, Монголбанк, НЗДТГ
				2000-аас доошгүй	235.7 Гадаад эх үүсвэр	
8.8	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.72.6 дахь заалт	Ган, төмөрлөг болон цементийн үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	140.0 ТХХТ	БХБЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, АНЗДТГ
Зорилт 9. Агаар, орчны бохирдлыг бууруулан, байгалийн нөөцийн хамгаалалт, зохиистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.						
9.1	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.3, 4.1.6 дахь заалт	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Агаарын бохирдлыг бууруулахад шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлын явц, хувиар	100	200.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	ЭХЯ, БОАЖЯ, НЗДТГ
				600.0	0.1 Улсын төсөв	БОАЖЯ
9.2	МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, 2.3.3. Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.1, 4.2.2 дахь заалт	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулах	Дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авсан хамгаалалтын захиргааны тоо	11	1.0 Гадаад эх үүсвэр, улсын төсөв	БОАЖЯ
				30	1.6 Улсын төсөв	БОАЖЯ



9.3	МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3.7 дахь заалт	Цаг уур, орчны шинжилгээний техник, технологийн шинэчлэл, сүлжээний өргөтгөл хийх	Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхагийн барилгын ажлын явц, хувиар	100	10.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	БОАЖЯ
			Байгаль орчны төв лабораторийн барилгын ажлын явц, хувиар	100		
			Цаг уур, орчны шинжилгээний газрын конторын барилгын ажлын явц, хувиар	100		
			Технологийн шинэчлэл хийх цаг уурын ертөөний барилгын тоо	6		
			Усны бохирдлыг тодорхойлох багаж, тоног төхөөрөмжийн тоо	2		
9.4	МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 4.2.3-4.2.5 дахь заалт	Хүн амын ундны болон ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлэх бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, гол, горхи, булаг, шандны эхийг хашиж хамгаалах	Гидрогеологийн дунд масштабын зураглал, хайгуул судалгааны ажлын тоо	3	1.5 Улсын төсөв	БОАЖЯ
			Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо	10	2.0 Орон нутгийн төсөв	БОАЖЯ
			Хамгаалалт хийх булаг, шандны тоо	100		БОАЖЯ
			Сүлжээнд холбогдсон усны хяналт-шинжилгээний харуулын тоо	50	1.0 Улсын төсөв	БОАЖЯ

9.5	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт-1, Төрөөс ойн талаар баримтлах бодлого /цаашид "ТОТББ" гэх/-ын 3.1, 3.2, 3.3, ЗГУАХ-ийн 4.1.4, 4.2.7 дахь заалт	Ой хамгаалал, ойжуулалтын ажлыг чанаржуулж, ойн нөхөн сэргээлтийн ажлыг дэмжих	Ойжуулалт, нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ, мянган га	7.5	8.0 Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад эх үүсвэр	БОАЖЯ
9.6	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГУАХ-ийн 4.4.3 дахь заалт	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулах	Ойн хөнөөлт шавьжийн хөнөөлийн голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га	30.0	2.2 Улсын төсөв	БОАЖЯ
9.6	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГУАХ-ийн 4.4.3 дахь заалт	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулах	Үйлчилгээний цогцолбор байгуулах ажлын явц, хувиар	50.0	2.8 Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт	БОАЖЯ, ЗТХЯ
9.7	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГУАХ-ийн 4.4.3 дахь заалт	"Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	30.0	90.0 Гадаад эх үүсвэр	БОАЖЯ
9.8	МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2, ЗГУАХ-ийн 4.2.5 дахь заалт	Ундны усан дахь Уран болон бусад хүнд металл тодорхойлох орчны шинжилгээний лабораторийг чадавхжуулах	Шинжилгээнд ашиглах тоног төхөөрөмж	1	0.4 Улсын төсөв	МХЕГ

9.9	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.6 дахь заалт	Байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тогтоох үнэлгээнд орон нутаг оролцдог байх, санхүүжилтийг төсөвт тусгах	Хууль бус үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх талбайн хэмжээ, га	100	-	БОАЖЯ
9.10	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.6 дахь заалт	Цөлжилт, газрын доройтлыг бууруулах	Шинэчлэх аргачлалын тоо	1	-	БОАЖЯ
Зорилт 10. Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүний чадавхыг сайжруулж, гамшгийн үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.						
10.1	МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр /цаашид "ГХТТББХ" гэх-ийн 5.10, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах	Шинээр баригдах аврах, гал унтраах ангийн тоо Их засвар хийх аврах гал унтраах ангийн тоо	1 2	1.6 Улсын төсөв	Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/
10.2	ГХТТББХ-ийн 5.4, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт	Аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	1.3 Гадаад эх үүсвэр	ОБЕГ
10.3	ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт	Гамшгийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулахыг барих	Шинээр барих механикжсан агуулахын тоо	2	86.4 ТХХТ	ОБЕГ

ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО

Зорилт 11. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлж, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр цогц арга хэмжээ авна.

11.1	МҮТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх	Хамран сургалтын бохир жин, хувиар Шинээр ашиглалтад орох цэцэрлэгийн тоо Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийг камержуулах хувь	85.0	80.6 Улсын төсөв	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /цаашид "БСШУСЯ" гэх/
				85		
11.2	МҮТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6, 3.2.14 дэх заалт	Ерөнхий боловсролын суралгчдын аюулгүй, ая тухтай сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх	Гурван ээлжээр хичээллэж буй сургуулийн тоог бууруулах, хувиар Шинээр ашиглалтад орох Ерөнхий боловсролын сургуулийн тоо Орчин нөхцөлийг сайжруулах дотуур байрны тоо Аюулгүй загвар орчин бүрдүүлэх сургуулийн тоо Шинээр сонгон, секц, дуулийлан хичээллэх төвийн тоо	100	118.1 Улсын төсөв	БСШУСЯ
				62	18	



11.3	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.10 дахь заалт	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн түрээсийн тогтолцоог нэвтрүүлэх	Сурах бичгийн "Түрээсийн сан" байгуулах ажлын явц, хувиар	100	3.4 Улсын төсөв	БСШУСЯ
11.4	МУТХҮБ-2030-ын 2.2.3, ЗГҮАХ-ийн 3.2.6 дахь заалт	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгох	Дотуур байранд бага ангийн хүүхдтэй ажиллах асрагч-багш, хүүхэд хөгжлийн багшийн тоо	122	0.8 Улсын төсөв	БСШУСЯ
11.5	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.18 дахь заалт	Дээд боловсролын байгууллагын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн магадлан итгэмжлүүлэх	Мэргэжил дээшлүүлэх багшийн тоо	700	0.15 Гадаад эх үүсвэр	БСШУСЯ
11.6	ЗГҮАХ-ийн 3.3.3 дахь заалт	Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн давхардлыг арилгаж, зарим хөтөлбөрийг нийслэлийн алслагдсан дүүрэг, хөдөө орон нутагт шилжүүлэх	Магадлан итгэмжлэгдэх хөтөлбөрийн тоо	Дотоод-30, Гадаад-5	0.15 Улсын төсөв	БСШУСЯ
11.7	ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт	Багш нарын цалин, урамшууллыг нэмэх	Шилжүүлэх хөтөлбөрийн тоо	10-аас доошгүй	-	БСШУСЯ
			Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	33.2 Улсын төсөв	Засгийн газар

Зорилт 12. Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлж, бүх нийтийн биеийн тамирын хөгжилд төрөөс дэмжлэг үзүүлнэ.					
12.1	ЗГУАХ-ийн 3.2.47 дахь заалт	Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд инновац, техник, технологийн ололтыг нэвтрүүлэх	Шинээр ашиглалтад оруулах сумдын соёлын төв, театрын тоо	27	34.8 Улсын төсөв БСШУСЯ
			Шинээр ашиглалтад оруулах спорт цогцолбор, заалны тоо	6	
			Шинээр нэвтрүүлэх техник, технологи	3-аас доошгүй	
12.2	ЗГУАХ-ийн 3.2.56 дахь заалт	Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэсэн иргэний үйлчилгээний төлбөрт эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	БСШУСЯ, Эрүүл мэндийн яам /цаашид "ЭМЯ" гэх/
12.3	ЗГУАХ-ийн 3.2.58 дахь заалт	Соёл, урлаг, шинжлэх ухааны салбарын ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	Төрийн үйлчилгээний бусад албан хаагчдын жишиг хүргэх	20-50 хувиар нэмэх	1.2 Улсын төсөв БСШУСЯ



12.4	МУТХУБ-2030-ын 2.1.2, Зорилт 1	2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараахь үеийн түүх, археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	БСШУСЯ
Зорилт 13. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ.						
13.1	ЗГҮАХ-ийн 3.2.35, Төрөөс шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого /цаашид "ТШУТТББ" гэх-ын/ 4.4.1, 4.4.5 дахь заалт	Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх	Сургалтад хамрагдах, мөргөжил дээшлүүлэх судлаачийн тоо	200	5.0 Улсын төсөв	БСШУСЯ
13.2	МУТХУБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.93 дахь заалт	Хөдөө орон нутгийн интернетийн үйлчилгээ хүрээгүй сумд, стратегийн болон аялал жуулчлалын бүс нутаг, хүн ам ихээр төвлөрдөг газарт утасгүй интернетийн үйлчилгээг хүргэх	Интернетийн үйлчилгээ хүргэх цэгийн тоо	20	0.3 Бүх нийтийн үйлчилгээ-ний үүргийн сан	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар /цаашид "ХХМТГ" гэх/
13.3	ЗГҮАХ-ийн 5.1.18 дахь заалт	Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох	Шилэн кабельд холбогдох сумын тоо	2	1.5 Улсын төсөв	ХХМТГ

13.4	ЗГҮАХ-ийн 3.2.33 дахь заалт	Шинжлэх ухаан технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох	Үндэсний номын сангийн барилгыг дуусгаж, ашиглалтад оруулах ажлын явц, хувиар	100	7.2 Улсын төсөв	БСШУСЯ
Зорилт 14. Төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.						
14.1	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 5.1.17 дахь заалт, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын 3.9.3 дахь заалт	Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний нэр төрөл	60	4.5 Улсын төсөв	ХХМТГ
14.2	ЗГҮАХ-ийн 5.2.8, 5.1.17 дахь заалт	Цахим албан хэрэг хөтөлөлийн болон цахим шуудангийн системийн үйл ажиллагааг эхлүүлэх, тоон гарын үсгийн хэрэглээг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ХХМТГ
14.3	ЗГҮАХ-ийн 5.2.8 дахь заалт	Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, шинээр байгуулагдсан хуулийн этгээд, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх үйлчилгээг онлайн горимд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Онлайн горимд шилжих үйлчилгээ, хувиар	50.0	-	Хууль зүй, дотоод хэргийн яам /цаашид "ХЭДХЯ" гэх/



14.4	ЗГҮАХ-ийн 5.2.9 дэх заалт	Иргэний болон хуулийн этгээдийн архивын цаасан баримтыг цахимжуулах ажлыг дуусгаж, бүртгэлийн дотоод хэрэглээ болон онлайн орчинд ашиглах боломжийг бүрдүүлэх	Цахимжуулах ажлын явц, хувиар	100	-	ХЗДХЯ
				20.0		
14.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.80, 2.81 дэх заалт	Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох	Газрын нэгдсэн цахим систем бий болгох ажлын явц, хувиар	80.0	2.0 Улсын төсөв	БХБЯ
				5000-аас багагүй		
14.6	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /цаашид "ТЭМТББ" гэх/-ын 2.4.4, 2.4.6, ЗГҮАХ-ийн 3.1.9, 3.1.16, 3.1.17 дахь заалт	Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд цахим систем нэвтрүүлэх	Цахим систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар	100	-	ЭМЯ
14.7	ГБҮБ-ын 6.27.5 дахь дэд заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.6, 5.6.9 дэх заалт	Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	Шинээр цахимжуулах үйлчилгээний нэр төрөл	14	-	Гадаад харилцааны яам /цаашид "ГХЯ" гэх/

Зорилт 15. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлнэ.

15.1	МУТХУБ-2030-ын 2.2.2, Зорилт 2, ТЭМТББ 2.4.2.2, ЗГҮАХ-ийн 3.1.8.дахь заалт	Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Хүүхдийн мэс засал, мэдрэлийн болон нярайн нэгжийг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх хэсэгт шинээр байгуулсан нэгдсэн эмнэлэг, хувиар 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, промиль	35.0	2.0 Улсын төсөв	ЭМЯ
				25-аас ихгүй		
15.2	МУТХУБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.1-2.4.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 3.1.3, 3.1.4, 3.1.10 дахь заалт	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эмчилгээ, оношилгооны чанарыг сайжруулах	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, промиль 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, промиль	72	4.6 Улсын төсөв, 0.04 Эрүүл мэндийг дэмжих сан	ЭМЯ
				10.0		
				2		

	<p>МҮТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 4, ТЭМТББ-ын 2.4.1, 2.4.5 дахь заалт ЗГҮАХ-ийн 3.1.12 дахь заалт</p>	<p>Зонхилон тохиолдох халдварт өвчний тандагт, сэргийлэлтийг сайжруулж, өвчний тохиолдлыг бууруулах</p>	<p>Пневмококкийн эсрэг дархлаажуулалтыг нэвтрүүлэх эрүүл мэндийн байгууллагын тоо</p>	<p>9 дүүрэг, 21 аймаг</p>	<p>13.7 Улсын төсөв</p>	<p>ЭМЯ</p>
15.3			<p>Вирус хепатит В, С вирусийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд хамрагдах 15-65 насны хүн ам, хувиар</p>	<p>90.0</p>		
15.4	<p>МҮТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1 ТЭМТББ-ын 2.4.4, 2.4.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 3.1.9, 3.1.16, 3.1.17 дахь заалт</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх</p>	<p>ЭМДС-гаас санхүүжих хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хувь</p>	<p>70 хүртэл</p>	<p>30.0 Эрүүл мэндийн даатгалын сан</p>	<p>ЭМЯ</p>
			<p>Шинээр ашиглалтад орох сумын эрүүл мэндийн төвийн тоо</p>	<p>8</p>		
			<p>Шинээр ашиглалтад орох Хоёрдугаар шатлалын эмнэлгийн тоо</p>	<p>5 нэгдсэн эмнэлэг, 2 өргөтгөл</p>		

15.5	ТЭМТББ-ын 2.4.5, ЗГҮАХ-ийн 3.1.22 дахь заалт	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнээс үүдэлтэй өрсдэлээс урьдчилан сэргийлэх	Шинээр ашиглалтад орох Гуравдугаар шатлалын эмнэлгийн тоо	4	57.0 Улсын төсөв	ЭМЯ
				100		
15.6	ЗГҮАХ-ийн 3.1.6 дахь заалт	Халдварт /сүрьеэ/ өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх	Эрт илрүүлэх үзлэгийг нэмэгдүүлэх, оношилж эмчлэх, хувиар	-	0.5 Улсын төсөв	ЭМЯ
				-		
15.7	ЗГҮАХ-ийн 3.1.6 дахь заалт	Сүрьеэгийн эмнэлгийн барилга шинээр барих /360 ортой/	Шинээр байгуулах, эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар	50	10.0 Улсын төсөв	ЭМЯ



Зорилт 16. Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.						
16.1	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зохион байгуулалттай болон хувь хүний ур чадварт түшиглэсэн ажлын байр бий болгох	Бий болох ажлын байрны тоо, мянга	45.0-аас доошгүй	30.0 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /цаашид "ХЭДС"тэй/ 20.0 Гадаад эх үүсвэр	ХНХЯ
			Төсөл, хөтөлбөрт хамрагдах хүний тоо, мянга	60.0		
16.2	ЗГҮАХ-ийн 3.3.3 дахь заалт	"Гэрээт малчин" төсөл хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой болгох	Төсөлд хамрагдах гэрээт малчин өрхийн тоо	1000 орчим	2.0 ХЭДС	ХНХЯ
16.3	ЗГҮАХ-ийн 3.3.6 дахь заалт	Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадын ажиллагсдын тоог бууруулах	Гадаад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгох урьдчилсан зөвшөөрлийн тоог бууруулах, хувиар	20.0	-	ХНХЯ
16.4	ЗГҮАХ-ийн 3.4.9 дэх заалт	МСҮТ, Политехник коллежид элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд мэргэжил, ур чадварыг эзэмшүүлэх, МСҮТ-ийн оюутнуудад 70000 төгрөг олгох	Мэргэжил, ур чадварыг эзэмшүүлэх төгсөгчдийн тоо, мянга	20.0	-	ХНХЯ

16.5	МҮТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Төрийн албан хаагчдын ажлын ачаалал, үр дүн, хариуцлага, үр чадварыг дээшлүүлж, инфляцийн түвшинтэй уялдуулан цалинг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Засгийн газар, ХНХЯ
16.6	ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жил тутамд нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогын түвшинг дээшлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	16.4 Улсын төсөв	ХНХЯ
16.7	МҮТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Ядуу, эмзэг бүлэгт олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	17.8 Улсын төсөв	ХНХЯ
16.8	МҮТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 1,	Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг бүлэг тус бүрт ялгавартайгаар хүргэх	Ядуурлаас гарах өрхийн тоо, мянган өрх	16.0-гаас доошгүй	-	ХНХЯ
16.9	ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Үнэ ханшны өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	119.5 Улсын төсөв	ХНХЯ

16.10	ЗГҮАХ-ийн 3.3.34 дэх заалт	Хүүхэд төрүүлсэн эхэд даатгуулсан хэлбэрээс үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Сайн дураар даатгуулсан эх дундаж цалингаас тэтгэмж авах хувь	100	4.5 Нийгмийн даатгалын сан /цаашид "НДС" гэх/	ХНХЯ
16.11	ЗГҮАХ-ийн 3.3.35 дахь заалт	Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	7.5 НДС	ХНХЯ
16.12	ЗГҮАХ-ийн 3.3.35 дахь заалт	0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бүрдүүлэх	Хамрагдах эхчүүдийн тоо	50.0 мянгаас доошгүй	16.0 Улсын төсөв 3.4 НДС	ХНХЯ
16.13	ЗГҮАХ-ийн 3.4 дэх заалт, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.1-4.3.9 дэх зорилт	Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлд чиглэсэн боловсрол, хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	Боловруулах төлөвлөгөө, стандартын тоо	2	0.1 Улсын төсөв	ХНХЯ
16.14	ЗГҮАХ-ийн 3.4.5 дахь заалт	Хүүхэд, өсвөр үеийнхэнд үндэсний өв соёлыг уламжлуулах, тэдний хүмүүжил, төлөвшилд чиглэсэн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо	5.0 мянгаас доошгүй	0.2 Улсын төсөв	ХНХЯ

16.15	ЗГҮАХ-ийн 3.4.4 дэх заалт	Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээ авч, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх	Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн явц, хувиар	100	-	ХНХЯ
16.16	ЗГҮАХ-ийн 3.4.11 дэх заалт	Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан зорилтот бүлгийн өсвөр үе, залуучуудад амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалтад хамруулах	Хамрах хүрээний хүн ам, хувиар	30.0	-	ХНХЯ
16.17	ЗГҮАХ-ийн 3.3.22 дахь заалт	Төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	30.0	0.1 Улсын төсөв	ХНХЯ
16.18	ЗГҮАХ-ийн 3.3.28 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох эзлтэй орчныг бүрдүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	50.0	0.2 Улсын төсөв	ХНХЯ
16.19	МУТХҮБ-2030-ын 2.2, ЗГҮАХ-ийн 3.3.27, 5.1.7 дахь заалт	Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	0.1 Улсын төсөв	ХНХЯ

16.20	ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт	Багш, эмч нарын цалин, хөлсний менежментийг боловсронгуй болгох замаар үе шаттайгаар цалин, хөлсийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ
ТАВ.ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО						
Зорилт 17. Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, төрийн албаны тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллана.						
17.1	Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 158, 161 дүгээр заалт	Шүүхийн шинжилгээний тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2	-	ХЗДХЯ
17.2	ЗГҮАХ-ийн 5.4.9 дэх заалт	Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1.3 Улсын төсөв, 34.1 гадаад эх үүсвэр	ХЗДХЯ
17.3	ЗГҮАХ-ийн 5.5.2 дахь заалт	Дотоодын цэргийн үйл ажиллагааг жигдрүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	4.7 Улсын төсөв	ХЗДХЯ

17.4	ЗГУАХ-ийн 5.4.14 дахь заалт	Хил хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техник хэрэгслийг нэвтрүүлэх	Буйр нуурын усан хил хамгаалалтад нийлүүлэх хөнгөн хөлгийн тоо	2	1.0 Улсын төсөв	ХЗДХЯ
				100	1.7 Улсын төсөв	
17.5	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ЗГУАХ-ийн 3.1.10, 3.1.11 дэх заалт	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материалаар хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	0.4 Улсын төсөв	ХЗДХЯ
17.6	ЗГУАХ-ийн 5.2.10 дахь заалт	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээний цогцолбор төв байгуулах	Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20.0	11.1 Улсын төсөв, 16.8 Гадаад эх үүсвэр	ХЗДХЯ
17.7	ЗГУАХ-ийн 5.3.7 дахь заалт	Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх	Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	1.6 Улсын төсөв, 0.1 Гадаад эх үүсвэр	ХЗДХЯ

17.8	ЗГУАХ-ийн 5.1.11 дэх заалт	Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Төрийн албаны зөвлөл
17.9	ЗГУАХ-ийн 5.4.12 дахь заалт	Хууль сахиулах их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилгыг барих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	20.0 Улсын төсөв	ХЗДХЯ
Зорилт 18. Төрийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, стандарт хэмжил зүйн байгууллагын олон улсын итгэмжлэлийн үйл ажиллагааг сайжруулна.						
18.1	МУТХУБ-2030-ын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.7 дахь заалт, ЗГУАХ-ийн 2.7 дахь заалт	Ноос, ноолуур, арьс шир, оёмол бүтээгдэхүүн, аялал жуулчлал, хүнсний салбарын үндэсний стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх	Шинээр боловсруулж батлуулах стандарт	5	-	Стандарт, хэмжил зүйн газар /цаашид "СХЗГ" гэх/
18.2	МУТХУБ-2030-ын 2.1.3, 2.1.5 дахь заалт, ЗГУАХ-ийн 2.8 дахь заалт,	Улсын эталоны нэрийвчлалын түвшинг дээшлүүлж, баталгаажуулалтын болон эталон лабораторийг байгуулах	Шинээр байгуулах лаборатори	2	-	СХЗГ
18.3	МУТХУБ-2030-ын 2.1.3, 2.1.5 дахь заалт , ЗГУАХ-ийн 2.8 дахь заалт	Олон улсын итгэмжлэлийн байгууллагын хэлэлцээрт нэгдэх	Нэгдэн орох хэлэлцээр	2	0.05 Улсын төсөв	СХЗГ

18.4 ЗГУАХ-ийн 5.2.1 дэх заалт	Төрийн өмчийн талаархи бодлого боловсруулан хэрэгжүүлэх, удирдлага менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах үйл ажиллагааг ил тод болгох, өрсөлдөх тэгш боломжоор хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинэчлэн найруулах хууль Нэмэлт, өөрчлөлт оруулах журам	1 1	-	ТӨБЭЗГ
Зорилт 19.Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийн зэрэгцээ хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлнэ.					
19.1 Гадаад бодлогын үзэл баримтлал даашид “ГБУБ” гэх/3.21.6 дахь заалт, ЗГУАХ-ийн 5.6.5, 5.6.7 дахь заалт	Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	Замын-Үүд-Эрэний чөлөөт бүс байгуулах ажлын явц, хувиар	80.0	-	Шадар сайдын Ажлын алба, ГХЯ, СЯ
19.2 ЗГУАХ-ийн 5.6.5, 5.6.8 дахь заалт	Монголын бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг бууруулах	Яриа хэлэлцээр хийх орон	2	0.14 Улсын төсөв	ГХЯ



19.3	ГБҮБ-ын 2.14.1 дэх заалт, ЗГҮАХ-ийн 5.6.2 дахь заалт	Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.2 Улсын төсөв	ГХЯ
19.4	ГБҮБ-ын 6.27.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9, 5.6.12 дахь заалт	Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар Нэмэлт, өөрчлөлт оруулах дүрэм	2 1	-	ГХЯ
Зорилт 20. Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний барилгын засвар төслийг хэрэгжүүлнэ.						
20.1	ЗГҮАХ-ийн 5.5.5 дахь заалт	Зэвсэгт хүчний энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	2.9 Улсын төсөв, 1.0, Зэвсэгт хүчний хөгжлийн сан /цаашид "ЗХХС" гэх/	Батлан хамгаалах яам /цаашид "БХЯ" гэх/
20.2	ЗГҮАХ-ийн 5.5.6 дахь заалт	"Барилгын засвар" төслийг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын барилга, байгууламжийн их засварын ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	0.5 Улсын төсөв, 1.3 ЗХХС	БХЯ, Зэвсэгт хүчний жанжин штаб /цаашид "ЗХЖШ" гэх/

20.3	ЗГҮАХ-ийн 5.5.5 дахь заалт	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн ротыг бэлтгэж, оролцуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	БХЯ, ЗХЖШ
20.4	ЗГҮАХ-ийн 5.5.6 дахь заалт	Материал, хэрэгслийн нөөцийг зэвсэгт хүчний хэмжээнд оновчтой шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	БХЯ, ЗХЖШ
20.5	ЗГҮАХ-ийн 5.5.2, 5.5.10 дахь заалт	Зэвсэгт хүчний лабораторийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2030/-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	10.0	0.6 ЗХХС	БХЯ

-----000-----



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт, 6.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорждугарын Гантулгыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Н.Амарзаяа, Ё.Баатарбилэг, Ж.Батзандан, Д.Ганболд, Х.Нямбаатар нараас 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018 оны 06 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 16.15 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Ш.Цогтоо /илтгэгч/, Б.Буяндэлгэр нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч А.Базар, П.Ундрах-Эрдэнэ болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, мөн зүйлийн 31.4 дэх хэсэг, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн А.Базар, Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Э.Ариунзаяа нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн дагуу төлбөр авагч нь худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсыг түүнд буцаах бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн дагуу гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин ирүүлэхгүй буюу цаашид тухайн асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэхгүй байх үр дагавартай байна.

Төлбөр авагч нь өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо сэргээлгэхээр шүүхэд хандсаны дагуу шүүхийн зүгээс түүний зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлж, буруутай этгээдээс төлбөр авах эрхтэй болохыг нь баталгаажуулсан шүүхийн шийдвэр гардаг. Үүний үндсэн дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг. Шүүхийн шийдвэр гарч байгаа

нь төлбөр авагч буюу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэний эрхийг хууль зүйн хувьд сэргээж байгаа явдал бол нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг бодитойгоор сэргээн эдлүүлэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг. Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох нь иргэний зөрчигдсөн эрхээ сэргээн эдлүүлэх, бодитойгоор хамгаалуулах боломжгүй байдалд хүргэж байгаа хэрэг юм.

Дуудлага худалдаа нь үнэ өрсөлдүүлэх буюу хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд хөрөнгийг худалдах ажиллагаа тул зах зээлийн хамгийн өндөр үнийг олох боломжтой. Иймд дуудлага худалдаанд түүний тогтоосон үнэлгээний 50 хувиар оруулахад худалдан борлогдоогүй эд хөрөнгийг зах зээлд ямар ч этгээд тийнхүү үнээр авах сонирхолгүй буюу үнэ цэнэгүй хөрөнгө гэж үзэх үндэслэлтэй юм. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн этгээд болох төлбөр төлөгчийг албадах, төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ажиллагаа байх ёстой. Гэтэл дээрх заалт нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагыг зөрчигдсөн эрхээ сэргээлгэх гэж буй төлбөр авагчид чиглүүлсэн зохицуулалт байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна.

Мөн иргэн А.Базар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “... 31.1.2 ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг хянуулахаар мэдээллийн шаардлагын хэмжээг ихэсгэсэн болно.

Хоёр. Нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Ундрах-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг дараах үндэслэлээр төлбөр авагчид буцаана” гэж заасан ба 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр



авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан” гээд мөн зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэжээ.

Өөрөөр хэлбэл, төлбөр авагч нь төлбөр төлөгчөөс хураалгасан худалдан борлогдоогүй эд хөрөнгийг заавал төлбөртөө тооцон авах ба хэрэв авахгүй бол өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжгүй, шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин хандах эрхгүй байхаар зохицуулсан нь төлбөр авагчийн эрх зүйн байдлыг дордуулж, Үндсэн хуульд заасан “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” иргэний үндсэн эрхийг хязгаарласан байна. Нэгэнт шүүхийн шийдвэр гарсан бол түүний зөрчигдсөн эрхийг гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн хуулийн дагуу сэргээх бөгөөд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх хүчинтэй байх ёстой юм.

Төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө тооцон авахаас татгалзсан бол тухайн гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж болох боловч төлбөр авагч нь тухайн шийдвэрийг биелүүлэхээр шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирүүлэх эрхтэй байх ёстой. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахин шинээр эхлэн төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хуульд заасны дагуу эрэх олох ажиллагааг явуулж, төлбөр авагчийн төлбөрийг барагдуулна.

Ингэснээр шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх хууль зүйн боломж хадгалагдан үлдэх юм.

Өмнө мөрдөгдөж байсан 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1-д заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.” гэж заасан байв. Өөрөөр хэлбэл өмнөх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчөөс гаргуулсан худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө тооцон авахаас татгалзсан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болохгүй байв.

Гэтэл шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар энэ боломжийг хааж, төлбөр авагч нь төлбөр төлөгчийн худалдан борлогдоогүй хөрөнгийг заавал авах, ийнхүү аваагүй бол гүйцэтгэх баримт бичгийг дахин ирүүлэх эрхгүйгээр буцааж буй нь шүүхийн шийдвэр гарсан хэдий ч иргэн өөрийнхөө хохирлыг хэзээ ч барагдуулах боломжгүй нөхцөл байдал бий болгож байна.

Иймд Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн эсэхийг тогтоож дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлжээ.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн хөрөнгө албадан дуудлага худалдааны журмаар худалдан борлогдоогүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангаж, төлбөр авагчийн төлбөрийг барагдуулах зорилгоор төлбөр авагчид худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт санал болгох шаардлага үүсэх бөгөөд энэхүү ажиллагааг дээрх хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу явуулж, үр дүнг нь мөн хуулийн 31.1.2 дахь заалтыг үндэслэн шийдвэрлэхээр хуульчилсан.

Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт заасан хөрөнгө, түүнчлэн зарим шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгчийн бүхий л хөрөнгөд ажиллагаа явуулсны үндсэн дээр санал болгосон хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзах нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүй болгох төдийгүй төлбөр төлөгчийн боломжийг хаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа олон жил үргэлжлэх, мөн хугацаагаар эргээд төлбөр авагчийн хохирлыг барагдуулах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхгүй байх нөхцөлийг үүсгэхээр байна.

Төлбөр авагчийн хувьд хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн нь тогтоогдож, уг зөрчигдсэн эрхийг нь сэргээхээр заавал биелэгдвэл зохих хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан гэдэг утгаараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эрхийг нь хамгаалах гол оролцогч хэдий ч нөгөө талд нь Монгол Улсын Үндсэн хуулиар эрх, ашиг сонирхол нь хамгаалагдсан, албадлагын шинжтэй арга хэмжээний үйлчлэлд өртөж байгаа төлбөр төлөгчийн эрх ашиг мөн байгаа гэдгийг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй.” гэж заасан нь төлбөр авагчид төлбөр төлөгчийн хөрөнгөөс өөрт таалагдсан, дурын хөрөнгийг сонгож төлбөрт гаргуулах эрхийг олгосон заалт гэж үзэхгүй байна.

Шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн эрхийг хангаж, хохирлыг барагдуулахаар хуульд заасан бүх ажиллагааг хийж гүйцэтгэж, төлбөр төлөгчөөс өөр хөрөнгө байхгүй байгааг баталсан байхад төлбөр авагч санал болгосон хөрөнгийг авахгүй байх нь гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож, зөвхөн өөртөө таалагдсан хөрөнгийг сонгож авах, энэхүү хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн таалагдсан хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжлэх үр дагаврыг үүсгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж, түүний дотор шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх талаарх зохицуулалт нь төлбөр авагчийн эрх ашигт нийцсэн байхаас гадна төлбөр төлөгчийн эрхийг мөн хамгаалах нь зүйтэй гэж үзэж байна.



Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад заасан үндэслэлээр буцаасан гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгүүлэхээр хэдэн ч удаа дахин ирүүлэхээр өөрчилбөл төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож, зөвхөн өөрт таалагдсан буюу өөрт хэрэгтэй гэж үзсэн хөрөнгийг сонгож авах, энэ тухай хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн хүссэн хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжилж болох хязгааргүй байдлыг үүсгэнэ. Энэ нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчихөд хүргэж, хэн боловч ямар ч цаг хугацааны хязгааргүйгээр төлбөр төлөгч болох, хэдийд ч тэдгээрийн эрхэд халдаж болох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Иргэний эрх зүйн маргааны талууд өөрсдийн зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, шүүхэд нэхэмжлэл гаргах, нотлох баримт цуглуулах эрх, үүргээ хэрэгжүүлэх эсэхээ өөрөө бие даан шийдэж хэрэгжүүлдэг, үүний нэгэн адил хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг албадан биелүүлсний үр дүнд бий болсон хөрөнгө, эсхүл шүүхийн шийдвэрт төлбөр авагчид шууд шилжүүлэхээр заасан хөрөнгийг хүлээн авах, эсхүл хүлээн авахаас татгалзах нь төлбөр авагчийн өөрийнх нь эрх хэмжээний асуудал гэж үзэж байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "... 31.1.2 ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох хэсгийг зөрчөөгүй." гэсэн агуулга бүхий тайлбаруудыг гаргажээ.

Дөрөв. Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"Худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө авахаас татгалзсан тохиолдолд төлбөр төлөгч уг эд хөрөнгөөс өөр эд хөрөнгө, банкинд мөнгөн хадгаламж болон харилцах дансанд мөнгөн хөрөнгө, орлогогүй болохыг шийдвэр гүйцэтгэгч холбогдох баримтаар тогтоосон бол төлбөр авагчид гүйцэтгэх баримт бичгийг буцаана гэж шүүхийн практикт тайлбарлан хэрэглэж байсан ба одоо ч энэ тайлбар ач холбогдолоо алдаагүй байна.

Төлбөр төлөгчийн борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзсан, шийдвэр гүйцэтгэлийн байгууллага төлбөр барагдуулах боломжтой бүхий л ажиллагааг хийсэн боловч өөр хөрөнгө тогтоогдоогүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах нь төлбөр төлөгчийн тухайн үеийн эд хөрөнгийн байдалтай холбоотой бөгөөд харин шүүхийн шийдвэр биелэгдэх зарчимтай тул гүйцэтгэх баримт бичгийг буцааж авч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах боломж нээлттэй байх ёстой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэгт гүйцэтгэх баримт бичгийг буцаахдаа дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй гэж хуульчилсан байсныг 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болгож, тус хуулийн 17.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.” гэж өөрчилж, Үндсэн хуульд нийцүүлсэн байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ийнхүү залруулж зөвтгөж байсан атлаа 2017 оны шинэчилсэн найруулгын 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь төлбөр авагчийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үндсэн эрхэд нийцээгүй агуулгатай болсон байна.” гэсэн байна.

Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах” эрх зүйн зохицуулалт нь 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39.8, 48.7 дахь хэсэгт тусгалаа олж, үйл ажиллагаанд 15 жилийн хугацаанд мөрдөгдөж ирсэн нь Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсэгт тус тус дээрх эрх зүйн зохицуулалтууд хэвээр хуульчлагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэх” эрхгүй байхаар хуульчилсан нь төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, төлбөрийн шаардлага хангуулахаар гаргуулсан эд хөрөнгө худалдан борлогдоогүй, уг эд хөрөнгөөс өөр хөрөнгө байхгүй тохиолдолд төлбөр авагчид хөрөнгө санал болгох ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон байна.

Угажиллагааны зорилгонь төлбөр төлөгчийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, тэдгээрийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, өөрт ашиг, орлого бий болгохуйц эд хөрөнгийг авах, эсхүл өндөр үнийн дүнтэй хөрөнгийг өөрийн бага төлбөрийн шаардлагад нийцүүлэн авах төлбөр авагчийн шаардлагыг хуулиар хязгаарлаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын тэгш эрхийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдсэн.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад иргэн А.Базар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 болон 73.4 дэх хэсэгт “... худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр



төлөгчид, ..." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болно.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж, түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн байна.

Учир нь дээр дурдсан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан гүйцэтгэх баримт бичгийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байх талаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн зохицуулалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлбөр авагч хөндөгдсөн эрхээ сэргээлгэхээр дахин хандах эрх зүйн боломжийг үгүйсгэж, төлбөр авагчийн эрхийг бүрэн хязгаарласан заалт болсон гэж үзэхээр байна. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үр дагаврыг бий болгож, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх эрх зүйн зарчмыг зөрчсөн байна. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй." гэж заасан нь төлбөр авагчийн хөндөгдсөн эрх, ашиг сонирхлоо бодитоор сэргээлгэх хууль зүйн баталгааг үгүй болгосон гэж үзэж байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаахаар заасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн дуусгавар болгох эрх зүйн үр дагаврыг бий болгохооргүй байх бөгөөд иргэдийн мэдээлэлд дурдсан Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх заалтад шууд хамааралгүй гэж үзэхээр байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад "төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан," 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт "... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.", 73.4 дэх хэсэгт "... Төлбөр авагч татгалзсан бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ...

хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль зүйн техникийн хувьд засаж залруулах шаардлага байгаа талаар дурдах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан;”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.



5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

6.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

Н.ЧИНБАТ

Д.ГАНЗОРИГ

Ш.ЦОГТОО

Б.БУЯНДЭЛГЭР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3,5

Индекс: 200003